

Япон хүний нүдээр үзсэн Монгол орон (1945-1947 он)

Ж. Урангуа

Дэлхийн II дайны төгсгөлд Ази, Номхон далайд өрнөсөн дайнд БНМАУ ЗХУ-тай 1936 оны 3 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан "Харилцан туслалцах гэрээ"-нд заасан үүргээ биелүүлэх үүднээс 1945 оны 8 сарын 9-ны өдөр нэгдэн орсон юм. Дайны үеэр ЗХУ тус бүс нутгаас олзлон авсан 640.105 япончуудын дундаас 12318 хүнийг нэрсийн жагсаалтгүйгээр тоолон авч, 6 удаагийн цуваагаар Монголд авчирсан юм. Тэдний дотор ахлах офицер 15, дунд офицер 678, бага дарга 2178, цэрэг 8079, энгийн япон албан хаагч 1368 хүн байжээ.

БНМАУ 1945 оны 11 сарын 20-ноос 1947 оны 10 сарын 26-ны хооронд тэдгээр япончуудыг тус улсад биеийн хүчний хөдөлмөр эрхлүүлж байсан.

Олзлогдсон япончуудыг Монголд хүлээн авах, байршуулах болон тэдний хөдөлмөр эрхлэлтийн талаар судлаач Ч.Дашдаваа, Б.Эрдэнбилэг нар судлан бичсэн бүтээлүүд бий.

Гэхдээ япон хүмүүсийн бие мах бодь, сэтгэл санааны үүднээс асуудалд хандсан судалгаа манай оронд огт хийгдээгүй байгаа.

Гэвч эдгээр зүйлсийг нээн гаргах эх сурвалжууд манай Архивад байна. Гиймээс Монгол Улсын Гадаад хэргийн яам болон Тагнуулын Ерөнхий газрын тусгай Архивд хадгалагдаж байгаа япон хүмүүсээс манай засгийн газарт болон өөрийн орны зохих байгууллагад хандан бичиж байсан захидлууд дээр үндэслэн Монгол орон япон хүний нүдээр харахад ямар байсан болон олзлогдон ирсэн япончуудын хөдөлмөр эрхлэлт, аж байдал ямар байсан болон тэдэнд тулгарч байсан бэрхшээлүүдийн талаар энэхүү илтгэлд өгүүлэх болно. Чингэхдээ би Монгол Улсын гадаад хэргийн яамны Архивд хадгалагдаж байгаа олзлогдсон япон иргэдээс Монголын Засгийн газар, Гадаад яам болон өөрийн Япон орныхоо Гадаад хэргийн яам, Японы улаан загалмайн нийгэмлэгт бичсэн 14 захидал болон Монгол оронд үлдэхийг хүссэн нэгэн эрийн захидал, мөн цэргийн биш боловч олзлогдон ирсэн 301 хүн нэр хамтран гарын үсэг зурж бичсэн удаа дараагийн Гуйлт бичиг, мөн япон эмч нарын бичсэн тодорхойлолтууд зэрэг бичиг баримтуудыг судалгааны эх сурвалжаа болгосон болно. Тэгээд тухайн үеийн Монгол орны байдал японы хүний сэтгэл санаанд хэрхэн тусч байсныг дэлгэн тавина.